



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 16-ны өдөр

№ 2026/5

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Компанийн “Ногдол ашгийн бодлого”-ын 2 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн эчнээ шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгийн 25% (хорин тав) буюу 1,106,560,000 (нэг тэрбум нэг зуун зургаан сая таван зуун жаран мянга) төгрөгийг нэгж хувьцаанд 3.04 (гурван төгрөг дөрвөн мөнгө) төгрөгөөр тооцож, ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлэлцээр байгуулж гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т олгож, тогтоосон хугацаанд хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахыг үүрэг болгосугай.
5. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Монголын Хөрөнгийн биржид зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Есү-Үжин)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ